



# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2009 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Нэрийн дансны орлогод тооцох хүүгийн  
хэмжээг өөрчлөн тогтоох тухай

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны санал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2008 оны 1 тоот тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох 2000-2006 оны хүүгийн хэмжээг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох 2007 оны хүүгийн хэмжээг 15.8 хувиар тогтоосугай.

Гурав. Хавсралтаар батлагдсан хүүгийн хэмжээг баримтлан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны эхний үлдэгдэл, 2000-2006 оны орлогын хэмжээг дахин тооцож, нэрийн дансны 2007 оны жилийн эцсийн үлдэгдлийг баталгаажуулах ажлыг 2009 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар (Ч. Алтанхуяг)-т даалгасугай.

Дөрөв. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2000 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 03, 2001 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 14, 2003 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 02, 2003 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 17, 2005 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 05, 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 30, 2007 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Тав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (М. Батаа)-нд даалгасугай.



Д. НЯМХҮҮ



ЗӨВЛӨЛ  
Нийтийн даатгалын үндэсний зөвлөлийн  
2009 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн  
11 дүгээр тогтоолын хавсралт

ДААТГУУЛАГЧДЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ОРЛОГОД  
ТООЦОХ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭ

	Онууд	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Хүүгийн хэмжээ (хувиар)	13,0	14,0	14,0	5,0	11,0	7,0	11,1	